

2022 он 09 сарын 28-ны өдөр

№444/22

МУИС, ХШУИС-ИЙН ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН,
ОЙН ИНЖЕНЕРЧЛЭЛИЙН ТЭНХИМ -Д

Санал хүргүүлэх тухай

Хотын логистик хичээлийн агуулгатай танилцсаны үндсэн дээр дараах санал, хүсэлтүүдийг илгээлээ.

Санал 1:

Агуулга ерөнхийдөө байгаль орчин талаасаа, байгаль орчны нөлөөллийн асуудлуудыг авч үзсэн байна. Мөн зарим талаар хоорондоо зөрүүтэй ойлголтууд болох хотын логистик, маркетингийн логистик, хотын замын хөдөлгөөний асуудлуудыг хольж хутгасан байгааг залруулах шаардлагатай гэж үзэж байна.

Санал 2:

Хотын орон зай зүй тогтлын ерөнхий ойлголт, хот төлөвлөлт, бүс нутгийн таталцал нөлөөлөл, нийгэм -эдийн засгийн хамаарал, худалдаа болон үйлдвэрийн бүсүүдийн нөлөөллийн талаар хичээлийн агуулгад нэмж оруулбал салбарын асуудлыг бүрэн хамраана гэж үзэж байна.

Санал 3:

Дэд бүтцийн сүлжээ, авто болон төмөр зам, нисэх буудал, агуулах, зоорь гэх мэт элементүүдийн уялдаанд анализ хийх чадварыг хичээлийн семинар хөтөлбөрт уялдуулах шаардлагатай.

Та бүхэнд амжилт хүсье!

Хүндэтгэсэн,



Дунхуу Аюулан

Хот төлөвлөлтийн мэргэшсэн архитектор

ЛАНД ОВНЕР ХХК

www.landowner.mn